



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 07 өдөр

Дугаар #/350

Арвайхээр

Г Газар эзэмших эрх шинээр олгох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг Т.Намнансүрэнгийн 7 дугаар гудамж 741а тоотод байрлах 3880 м² газрыг Өвөрхангай аймгийн Зоонозын өвчин судалалын төв (РД9045966)-д эрүүл мэндийн байгууллагын зориулалтаар 40 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/123 дугаар захирамжийн Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газарт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Дээрх газар эзэмших эрх авсан хуулийн этгээдтэй газар эзэмших гэрээг байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100783